



## “МОНГОЛ ШУУДАН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 24/01

Улаанбаатар хот

### Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5, 46.16 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, Компанийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2, 4.3 дахь заалт, Улсын Их Хурлын 2021 оны 88 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 675 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Монгол шуудан” ХК-ийн 2023 оны цэвэр ашгийн дүнгээс 30.36 хувиар тооцож, нийт 597,518,178.00 (таван зуун ерэн долоон сая таван зуун арван найман мянга нэг зуун далан найм) төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилахыг зөвшөөрсүгэй.

2. Нэгж хувьцаанд 6.0 (зургаа) төгрөгийн ногдол ашиг тараахыг Гүйцэтгэх захирал /Б.Анхбаатар/-д үүрэг болгосугай.

3. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.

4. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар дамжуулан тарааж эхэлсүгэй.

5. Энэхүү ногдол ашиг хуваарилалтын шийдвэр болон 2022 оны ногдол ашиг тараасан талаарх тайланг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо /Д.Балдорж/-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ